



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/46/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь 2018 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
	Утас:7052-2734	Цахим хаяг: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	Ц.Лүндэгмаа
	Утас: 7052-3020	Цахим хаяг: .....
	Аудитор:	М.Бямбадорж
	Утас: 99031981	Цахим хаяг: <a href="mailto:mnbaudithk@gmail.com">mnbaudithk@gmail.com</a>

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

**АГУУЛГА**

1	Аудитын гэрчилгээ .....	33
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил .....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	

## 1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ  
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
С.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2019-02-23 № 16/116  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төв 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

9828999

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодож бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### ОРШИЛ

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч С.Мөнхжаргал-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 01-наас 2018 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК-д хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ийн гэрээт

“Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК-д 2018 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төв нь үйлчилгээний өргөн хүрээтэй орчинд, ажиллах чадамжтай чадварлаг боловсон хүчинтэйгээр, соёлын олон талт арга хэмжээг иргэдэд хүртээмжтэй хүргэж, аймаг улсад манлайлсан "Хүн хөгжлийн эрин зуун"-ы тэргүүлэгч байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Соёлын тухай хуулиар Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны урлаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох;
- соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;
- монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх;

- иргэдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран сайхан-гоо зүйн боловсрол, хүмүүжил олгох;
- олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;
- соёл судлалыг хөгжүүлэх;
- соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

байхгүй

#### **Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

#### **Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### **МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Байгууллага нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар алдагдалтай ажилласан байгаа тул нийт зардлын үзүүлэлтийг сууриа болгон сонгов.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны материаллагын түвшинг 257,211.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 2,572.11 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт зардлын 1 хувь буюу 2572.11 мянган төгрөгөөс хэтэрсэн алдааг материаллаг гэж үзэхтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

#### **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,997.20	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	1,997.20	

**2.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

“\_\_\_\_\_”

**ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

- Шилэн дансны хөтлөлт
- Цалин хөлсний тооцоолол, бүртгэл, тайлагнал

**Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 212175.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 214023.3 мянган төгрөгийн төсвийн батлагдсанаас цалингийн зардал 68487,4 мянган төгрөгийн төгрөгийн төсөв батлагдсанаас 66737,8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж 1749,6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь үндсэн шалтгаан болсон.

Өөрийн үйл ажиллагааны орлого 1838,5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 3686,0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан эсэх нь учир дутагдалтай байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь биелсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

**Илрүүлэлт**

2018 онд нийт 4223.1 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч 1082.1 мянган төгрөгийн буюу 26 хувийг зарцуулж 3141.0 мянган төгрөгөөр бараа материалын нөөц үүссэн байна. Жилийн нийт худалдан авалтын 86 хувь буюу 3632.1 мянган төгрөгийн худалдан авалтыг 12 дугаар сард гүйцэтгэсэн бөгөөд уг худалдан авалтаас 4911 мянган төгрөгийн буюу 14 хувийг зарцуулсан нь материаллаг нөөцийг нэмэгдүүлсэн байна. 2018 оны эхний 7 сард худалдан авалт хийгээгүй нь жил бүрийн төгсгөлд өндөр дүнгээр худалдан авалт хийж нөөц үүсгэн ажилдаг болох нь нотлогдож байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, тус тус зөрчсөн байна.

**Эрсдэл**

1. Материалын нөөцийн өсөлт нь материалын эргэлт удааширч материалын хорогдол, хоцрогдол үүсэх, төсвийн үр ашиггүй зардал нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

**Зөвлөмж**

Бараа материал худалдан авах төлөвлөгөөг баталж худалдан авалтыг гүйцэтгэх, хэрэгцээгүй бараа худалдан авах ажиллагааг таслан зогсоох.

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Иххэт сумын Соёлын төвийн эрхлэгч С.Мөнхжаргал, нягтлан бодогч Э.Сүглэгмаа

**Төсвийн захирагчийн хариу**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

#### ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ЛҮНДЭГМАА Огноо:

#### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР М.БЯМБАДОРЖ Огноо:

Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,997,707.00</u></b>	<b><u>28,421,091.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	27,000.00	1,997,184.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,000.00	1,366,165.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	631,019.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	631,019.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	24,970,707.00	26,423,907.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,970,707.00	26,423,907.00
35410	Бичиг хэргийн материал	611,140.00	1,510,640.00
35420	Аж ахуйн материал	24,359,567.00	24,913,267.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,308,370,303.84</u></b>	<b><u>1,019,252,087.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,308,370,303.84	1,019,252,087.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,308,370,303.84	1,011,044,087.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,979,282,360.00	1,028,774,005.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-697,640,835.01	-41,337,902.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,521,036.00	32,521,036.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,506,685.39	-28,536,160.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,739,912.80	13,739,912.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,187,018.23	-7,464,136.63
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	185,600.00	185,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,043,204.27	4,863,595.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,759,037.60	-3,861,428.73
39217	Ном	10,691,767.00	12,159,567.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	8,208,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	8,208,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,333,368,010.84</u></b>	<b><u>1,047,673,178.46</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>330,750.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	330,750.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	330,750.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	297,000.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	33,750.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	33,750.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,333,037,260.84</u></b>	<b><u>1,047,673,178.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,333,037,260.84	1,047,673,178.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	132,008,387.07	140,216,387.07
51101	Өмч: - төрийн	132,008,387.07	140,216,387.07
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	725,743,258.68	688,430,537.10
51210	Өмнөх үеийн үр дүн	725,743,258.68	728,033,258.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-39,602,721.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	475,285,615.09	219,026,254.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,333,368,010.84</u></b>	<b><u>1,047,673,178.46</u></b>

**Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>105,439,800.00</b>	<b>217,608,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,016,700.00</b>	<b>3,771,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,016,700.00	3,771,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,016,700.00	3,771,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,016,700.00	3,686,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	85,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>104,423,100.00</b>	<b>213,837,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	210,337,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	210,337,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,500,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	104,423,100.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	104,423,100.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>105,719,891.47</b>	<b>257,211,021.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>105,719,891.47</b>	<b>257,211,021.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	105,719,891.47	251,786,243.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	27,597,546.00	65,128,660.00
210101	Үндсэн цалин	27,597,546.00	65,128,660.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,126,924.00	7,798,402.00
210201	Тэтгэврийн даатгал	2,023,027.00	5,147,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	233,151.00	666,080.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	263,604.00	538,028.00
210204	Ажилгүйдлийн даатгал	55,195.00	152,633.00
210205	Эрүүл мэндийн даатгал	551,947.00	1,293,784.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,677,356.00	130,962,626.00
210301	Гэрэл, цахилгаан	2,209,387.00	3,937,618.00
210302	Түлш, халаалт	36,790,050.00	120,812,461.00
210303	Цэвэр, бохир ус	12,677,919.00	6,212,547.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,000.00	1,873,900.00
210401	Бичиг хэрэг	-	237,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	218,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,000.00	115,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	65,100.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,238,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	70,000.00	68,000.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	68,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,000.00	630,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	60,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,063,065.47	44,824,655.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,063,065.47	44,824,655.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	5,424,778.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,440,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	3,984,778.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,984,778.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(280,091.47)</b>	<b>(39,602,721.58)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(280,091.47)</b>	<b>(39,602,721.58)</b>

Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>105,439,800.00</b>	<b>217,523,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,016,700.00</b>	<b>3,686,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,016,700.00	3,686,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,016,700.00	3,686,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,016,700.00	3,686,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>104,423,100.00</b>	<b>213,837,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	210,337,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	210,337,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	104,423,100.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	104,423,100.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>83,104,726.00</b>	<b>217,523,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>83,104,726.00</b>	<b>217,523,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>83,104,726.00</b>	<b>212,098,522.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	27,597,540.00	66,737,827.00
210101	Үндсэн цалин	26,347,540.00	64,374,357.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,250,000.00	2,363,470.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,126,930.00	7,825,400.00
210201	Тэтгэврийн даатгал	1,756,174.00	5,465,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	274,291.00	590,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	342,539.00	472,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,748.00	118,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	685,178.00	1,179,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,677,356.00	131,593,645.00
210301	Гэрэл, цахилгаан	2,209,387.00	3,937,618.00
210302	Түлш, халаалт	49,053,400.00	120,812,461.00
210303	Цэвэр, бохир ус	414,569.00	6,843,566.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,000.00	3,138,950.00
210401	Бичиг хэрэг	00.00	1,250,750.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	218,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,000.00	115,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,382,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	172,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	246,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	246,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	508,400.00
210604	Урсгал засвар	00.00	508,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	44,200.00	68,000.00
210702	Дотоод албан томилолт	44,200.00	68,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	633,700.00	1,980,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	473,700.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	146,000.00	60,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,000.00	120,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>5,424,778.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,440,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	3,984,778.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,984,778.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>22,335,074.00</b>	<b>00.00</b>

Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,335,074.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,335,074.00	00.00

Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	132,008,387.07	475,285,615.08	15,446,198.22	622,740,200.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>132,008,387.07</b>	<b>475,285,615.08</b>	<b>15,446,198.22</b>	622,740,200.37
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(31,049,141.13)	(31,049,141.13)
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>132,008,387.07</b>	<b>475,285,615.09</b>	<b>725,743,258.68</b>	1,333,037,260.84
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>132,008,387.07</b>	<b>475,285,615.09</b>	<b>725,743,258.68</b>	1,333,037,260.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,290,000.00	2,290,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>132,008,387.07</b>	<b>475,285,615.09</b>	<b>728,033,258.68</b>	1,335,327,260.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(256,259,360.80)	-	(256,259,360.80)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	8,208,000.00	-	(39,602,721.58)	(31,394,721.58)
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>140,216,387.07</b>	<b>219,026,254.29</b>	<b>688,430,537.10</b>	1,047,673,178.46

Иххэт сумын Соёлын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	212,175,800.00	214,023,300.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	212,175,800.00	214,023,300.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	212,175,800.00	210,038,522.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	68,487,400.00	66,737,827.00
210101	Үндсэн цалин	65,515,700.00	64,374,357.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,971,700.00	2,363,470.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,827,200.00	7,825,400.00
210201	Тэтгэврийн даатгал	5,467,300.00	5,465,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	590,000.00	590,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	472,000.00	472,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118,000.00	118,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,179,900.00	1,179,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	131,796,100.00	131,593,645.00
210301	Гэрэл, цахилгаан	4,133,500.00	3,937,618.00
210302	Түлш, халаалт	121,468,400.00	120,812,461.00
210303	Цэвэр, бохир ус	6,194,200.00	6,843,566.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,097,000.00	1,078,950.00
210401	Бичиг хэрэг	196,700.00	190,750.00
210402	Тээвэр, шатахуун	230,000.00	218,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	115,100.00	115,000.00
210404	Ном, хэвлэл	382,800.00	382,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,400.00	172,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	246,800.00	246,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	246,800.00	246,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	508,400.00	508,400.00
210604	Урсгал засвар	508,400.00	508,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	96,400.00	68,000.00
210702	Дотоод албан томилолт	96,400.00	68,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,116,500.00	1,980,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,838,500.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	146,000.00	60,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	132,000.00	120,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	212,175,800.00	214,023,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	210,337,300.00	210,337,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	210,337,300.00	210,337,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,838,500.00	3,686,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,838,500.00	3,686,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	07.00	07.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00